



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠳᠢ  
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
 ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/205

Алтай хот

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, тус аймгийн "108 сая мод" тарьж, ургуулах арга хэмжээний хүрээнд хаврын бүх нийтээр мод тарих аяны тарьц, суулгацыг 19,500,000 (арван есөн сая таван зуун мянга) төгрөгөөр худалдан авах ажлыг шууд гэрээ байгуулан, гүйцэтгүүлэх эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар)-т шилжүүлсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан, гүйцэтгэгчийн ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (С.Амгалан)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР